



АРХАНГАЙ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 01

Эрдэнэбулган сум

Эх, нярай, хүүхдийн тусламж үйлчилгээг  
сайжруулах тухай

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 12 долоо хоногийн байдлаар 354 эх төрсөн ба, төрөлтийн байдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 тохиолдлоор буурсан байна.

Нийт төрсөн эхчүүдийн 299 нь аймгийн Нэгдсэн эмнэлэгт, 55 нь Сумын ЭМТөвд төрсөн.

Амьгүй төрөлт 3 тохиолдол бүртгэгдсэн нь аймгийн нэгдсэн эмнэлэгт 1, Өгийнуур сумын ЭМТөвд 2 байна. Гэрийн төрөлт 1 байгаа нь Улаанбаатар хотын харьяат эх байсан, өмнөх оны мөн үед гэрийн төрөлт бүртгэгдээгүй.

Нийт төрөлтийн 90 тохиолдол буюу 25,4 хувь нь кесар мэс заслаар төрсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,2 хувиар ихэссэн байна.

Дутуу төрөлт 19 байгаа нь 2 дахин ихэссэн, төрсний дараах 42 хоногт эргэж хэвтсэн эх 14 буюу өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор нэмэгдсэн, төрөх үеийн хүндрэл 11 тохиолдлоор буурсан боловч, төрөх хүчний хоёрдогч сулрал 18 тохиолдлоор, төрсний дараах цус алдалт 7 тохиолдлоор, УОШ эрт гарсан 6 тохиолдлоор тус тус нэмэгдсэн байна.

2020 оны 3-р сарын 21-нд Цэнхэр сумын Орхон багт төрөх дөхсөн эх гэртээ эндсэн.

Энэ хугацаанд хүүхдийн эндэгдэл өнгөрсөн оны мөн үеэс 4 тохиолдлоор нэмэгдсэн. Нийт хүүхдийн эндэгдлийн дотор 0-1 насны хүүхдийн эндэгдэл 8 буюу 72.7 хувь, үүнээс эрт нярайн эндэгдэл 3 буюу 27.3 хувь, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 3 тохиолдол буюу 27.3 хувийг эзэлж байна.

Хүүхдийн эндэгдлийн шалтгааныг харвал: осол гэмтэл, золгүй тохиолдол- 4, уушигны хатгалгаа-3, суулгалт-1, гэдэс цоорох-1, төрөх үеийн бүтэлт-1, төрлөхийн гажиг-1 тус тус байна.


Үүнээс үзэхэд эх, нярай, хүүхдийн үндсэн үзүүлэлтүүд өмнөх оны мөн үеэс буурсан байгаа нь эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадвар, дадлага туршлага, хандлага дутмаг, багаар ажиллах чадвар муу, иргэдэд эрүүл мэндийн боловсрол, тусламж хайх мэдлэг олгох сургалт үр дүнгүй, үзүүлж буй тусламжийн чанар хангалтгүй байгаагаас хожимдол, хүндрэл гарсаар байна.

Иймээс тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, хүндрэл эндэгдлээс урьдчилан сэргийлэхийн тулд эмч мэргэжилтнүүд ажлын хариуцлагаа сайжруулж, мэдлэг ур чадвараа дээшлүүлэн, стандарт удирдамжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор ДААЛГАХ нь:

НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, СУМ, ӨРХИЙН ЭМТ-ҮҮДИЙН ДАРГА НАРТ:

1. Эх барих эмэгтэйчүүдийн эмчгүй СӨЭМТ-д жирэмсэн эхийг эрхлэгч эмч нар хянах, хариуцах
2. АЗДаргын 2018 оны 307 тоот захирамжийг мөрдөж, эх нярай бүрийг нэрээр нь хянаж, нөхөн үржихүйн насны хөдөлгөөнт хүн ам болон, түр оршин суугчдын судалгааг үнэн зөв гаргаж, сар бүр шинэчлэх
3. Багийн эмч нарын эргэлт, хяналтыг тогтмол, чанартай хийлгэж, ажлын бүтээмжийг ажил дүгнэх үзүүлэлт, цалин урамшуулалтай нь уялдуулан тооцдог байх, багийн эмч нарын жирэмсэн эх, бага насны хүүхдийн гэрийн эргэлтэнд зориулж бензин шатахууныг тогтмол олгох
4. Төрөх хугацаа дөхсөн жирэмсэн эхчүүдийг эхийн амрах байранд хэвтүүлэн хянах
5. Эрсдэлтэй, эх барихын ужиг дурьдатгалтай эхчүүд, эмнэлгээс хол, зам харгүй бартаатай нутагт амьдардаг, ар гэрийн анхаарал халамж муу эхчүүдийг их эмч, эх баригч, багийн эмч нар хамтран хянаж, онцгой анхаарал хандуулах
6. Эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх, хүнд өвчтөн тээвэрлэхдээ дээд шатлалын эрүүл мэндийн байгууллагын нарийн мэргэжлийн эмч нартай заавал холбогдож, зөвлөгөө авч, зохих журмыг хэрэгжүүлэн ажиллах
7. Нэгдсэн эмнэлэгт жирэмсэн эх, хүүхдийн тусламжийг чирэгдэлгүй үзүүлэх ажлыг улам боловсронгуй болгох, ялангуяа амбулаторийн үзлэгийн ачааллыг судалж үзэх, ЖЗӨК-д тогтмол мэргэжлийн 2 их эмч ажиллуулах
8. Нэгдсэн эмнэлгийн эмч нар хэвтэн эмчлүүлээд гарсан эх болон хүүхдийн картанд “хэвтэн эмчлүүлсэн тухай” тэмдэглэл бичиж, дахин хэзээ, хаана үзүүлэхийг сайтар зөвлөж хэвших
9. Онцгойлон хянах шаардлагатай өвчтөн эмнэлгээс гарахад, эмчлэгч эмч нь сум, өрхийн ЭМТ-ийн эмч нартай холбогдож, мэдээлэл өгдөг байх
10. Иргэдэд тусламж хайх мэдлэг олгох сургалт явуулах, сайн дурын идэвхитнүүдийг олноор бэлтгэж, тэдний мэдлэгийг тогтмол сэргээх, идэвхийг өрнүүлэх ажлыг бүх эрүүл мэндийн байгууллагууд зохион байгуулах

Албан даалгаврын дагуу Эрүүл мэндийн байгууллагууд үр дүнтэй ажил зохион байгуулж, тайланг хагас бүтэн жилээр ЭТҮХэлтэст албан бичгээр ирүүлэхийг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА  Р.ГАНДИЙМАА

